



## БАЯН-ӨЛГИЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

### Гүйцэтгэлийн аудитын тайлан

**ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТААР  
ТӨСӨВЛӨЛТИЙН ШААРДЛАГА ХАНГААГҮЙ ТӨСӨЛ,  
АРГА ХЭМЖЭЭГ ТӨЛӨВЛӨСӨН БАЙНА**

**АУДИТЫН СЭДЭВ: “ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН  
2025 ОНЫ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН  
ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН”**

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дараах хаягаар авна уу.

Баян-Өлгий аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,  
тэргүүлэх аудиторын албан үүргийг түр  
орлон гүйцэтгэгч: Х.Женисбек

Утас: 70422954 Цахим хаяг: [jenisbekh@audit.gov.mn](mailto:jenisbekh@audit.gov.mn)

Аудитын менежер: Х.Женисбек

Утас: 70422930 Цахим хаяг: [jenisbekh@audit.gov.mn](mailto:jenisbekh@audit.gov.mn)

Ахлах аудитор: С.Нурлан

Утас: 99103281 Цахим хаяг: [nurlans@audit.gov.mn](mailto:nurlans@audit.gov.mn)

Аудитор: Р.Баярмаа

Утас: 99265539 Цахим хаяг: [bayarmaar@audit.gov.mn](mailto:bayarmaar@audit.gov.mn)

**2026 оны 05 дугаар сар**

2026 он

<b>ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТААР ТӨСӨВЛӨЛТИЙН ШААРДЛАГА ХАНГААГҮЙ ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭГ ТӨЛӨВЛӨСӨН БАЙНА</b> .....	1
Товчилсон үгийн тайлбар .....	3
Хүснэгтийн товьёг .....	4
Зургийн товьёг .....	4
Аудитын зорилт, хамарсан хүрээ, стандарт, арга зүйн талаарх мэдээгдэл.....	5
<b>А.ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТААР ТӨСӨВЛӨЛТИЙН ШААРДЛАГА ХАНГААГҮЙ ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭГ ТӨЛӨВЛӨСӨН БАЙНА</b> .....	7
<b>А.1. Төсөл арга хэмжээг аймгийн хөгжлийн жилийн бичигтэй уялдуулан төлөвлөсөн байна</b> .....	7
<b>А.2. Хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд төсөвлөлтийн шаардлага хангаагүй төсөл, арга хэмжээг тусгаж баталсан байна</b> .....	8
<b>А.3. Төлөвлөсөн нийт төсөл арга хэмжээний 92 хувь нь өмчлөлд шилжих хөрөнгө оруулалт байна</b> .....	9
<b>Б. ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААГ ЗОХИОН БАЙГУУЛАХАД ТӨРИЙН ХЭМНЭЛТИЙН ТУХАЙ ХУУЛИЙГ ХЭРЭГЖҮҮЛЖ АЖИЛЛААГҮЙ БАЙНА</b> .....	10
<b>Б.1 Төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг төлөвлөхдөө хууль журмыг хангалтгүй хэрэгжүүлсэн байна</b> .....	10
<b>Б.2 Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний тендерийн баримт бичиг баримттай холбоотой гомдол гараагүй байна</b> .....	12
<b>Б.3 Тендер шалгаруулалтын үр дүнг хуулийн хугацаанд бүрэн мэдээлээгүй байна</b> .....	12
<b>В.ЗАРИМ ТӨСӨЛ АРГА ХЭМЖЭЭГ ЗУРАГ ТӨСВИЙН ДАГУУ БҮРЭН ХИЙГЭЭГҮЙ БАЙХАД АШИГЛАЛТАД ХҮЛЭЭН АВСАН БАЙНА</b> .....	14
<b>В.1. Төсөл арга хэмжээг гүйцэтгэлийн дагуу санхүүжүүлж, гэрээг дүгнэсэн байна</b> .....	14
<b>В.2. Зарим төсөл арга, хэмжээг зураг төсөв, техникийн тодорхойлолтын дагуу гүйцэтгээгүй, хяналтыг хангалтгүй хэрэгжүүлсэн байна</b> .....	15
<b>В.3. Зарим төсөл, арга хэмжээг зориулалтын дагуу, бүрэн хүчин чадлаар ашиглаагүй байна</b> .....	17
<b>В.4. Хөрөнгө оруулалтын үр дүнд бий болсон хөрөнгийг ашиглагч байгууллагууд бүртгэлд бүрэн тусгаагүй байна</b> .....	24
<b>ДҮГНЭЛТ</b> .....	25
<b>Аудитын явцад цуглуулсан нотлох зүйл, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг хийж байна. Үүнд:</b> .....	25
1. Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтыг төлөвлөхдөө төсөвлөлтийн шаардлага хангаагүй төсөл, арга хэмжээг төлөвлөж батлуулсан байна. ....	25
2. Худалдан авах ажиллагааг зохион байгуулахад ТХТХ-ийг хэрэгжүүлээгүй байна. ....	25
3. Зарим төсөл арга хэмжээг зураг төсвийн дагуу бүрэн хийгээгүй байхад ашиглалтад хүлээн авсан байна.....	25
4. Худалдан авах ажиллагааны шийдвэр, тендерийн үр дүнг цахим системд хугацаанд нь бүрэн мэдээлээгүй байна. ....	25
<b>ЗӨВЛӨМЖ:</b> .....	25
<b>Аудитын дүн, дүгнэлт нотлох зүйлст үндэслэн дараах зөвлөмжийг өгч байна.Үүнд:</b> .....	25
<b>I.Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурын дарга /А.Бегарыс/-д:</b> .....	25
1. Аймгийн Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээний төсвийг батлахдаа Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 13.1-д заасныг мөрдөж ажиллах;	25
<b>II.Аймгийн Засаг дарга /Е.Зангар/-д:</b> .....	25
1. Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтад зураг төсөв нь хийгдсэн, төсөвлөлтийн шаардлага хангасан төсөл арга хэмжээг төлөвлөж, батлуулах;.....	25
2. Төсөл арга хэмжээний худалдан авах ажиллагаанд Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 13.1-д заасныг мөрдөж ажиллах;.....	25
3. Төсөл, арга хэмжээний хэрэгжилтэд тавих хяналт, хариуцлагыг сайжруулах; .....	25
<b>III. Худалдан авах ажиллагааны газрын дарга /Х.Нурсултан/-д:</b> .....	25
1. Худалдан авах ажиллагааны шийдвэр, тендерийн үр дүнг цахим системд хугацаанд нь мэдээлж ажиллах; .....	25
<b>IV. Хот байгуулалт, барилга захиалагчийн алба /С.Ержан/-д:</b> .....	25
4. Төсөл, арга хэмжээний гүйцэтгэлд тавих захиалагчийн хяналтыг үр дүнтэй хэрэгжүүлж ажиллах;.....	25
<b>Дээрх зөвлөмжүүдийг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг Төрийн аудитын тухай хуулийн 20.5-т заасан хугацаанд буюу аудитын тайланг хүлээн авснаас 30 хоногийн дотор, зөвлөмжийн биелэлтийг 2026 оны 12 дугаар сарын 01-ны өдрийн дотор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх.</b> ....	25

**Товчилсон үгийн тайлбар**

АДБОУС	Аудитын Дээд байгууллагын Олон Улсын стандарт
ААНБ	Аж ахуйн нэгж байгууллага
ЗДТГ	Засаг даргын тамгын газар
УИХ	Улсын Их Хурал
ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн хурал
ГА	Гүйцэтгэлийн аудит
ХАА	Худалдан авах ажиллагаа
ХААГ	Худалдан авах ажиллагааны газар
ТАХ	Төсөл, арга хэмжээ
ОНТХО	Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалт
БОНТХОБТ	Бүс орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалт, бодлого, төлөвл
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
ШХА	Шууд худалдан авалт
ТШЗ	Төсвийн шууд захирагч
ХДТ	Хөгжимт драмын театр
ХХААХҮС	Хүнс, хөдөө ахуй, хөнгөн үйлдвэрийн Сайд
ТХТХ	Төрийн хэмнэлтийн тухай хууль <sup>32</sup>

### Хүснэгтийн товьёг

№	Тайлбар	Хуудасны дугаар
Хүснэгт 1	Орон нутгийн төсвийн 2025 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөө	7
Хүснэгт 2	Төлөвлөсөн ТАХ төсөвт өртөг, тоон үзүүлэлтийн судалгаа	7
Хүснэгт 3	Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн судалгаа	8
Хүснэгт 4	Төсөвлөлтийн шаардлага хангаагүй төсөл арга хэмжээ	9
Хүснэгт 5	Хэрэгжүүлэх ТАХ нь өмчлөлд шилжих эсэхийн судалгаа	10
Хүснэгт 6	Худалдан авах ажиллагааны зохион байгуулалт	11
Хүснэгт 7	Төсөл арга хэмжээний санхүүжилтийн судалгаа	15
Хүснэгт 8	Гэрээ байгуулсан төсөл арга хэмжээний хэрэгжилтийн судалгаа	15
Хүснэгт 9	Цэцэрлэгүүдэд нийлүүлсэн тоног төхөөрөмжийн техникийн тодорхойлолт, үнийн харьцуулсан судалгаа	23

### Зургийн товьёг

№	Тайлбар	Хуудасны дугаар
Зураг 1	Онцгой байдлын газрын гарааш	18
Зураг 2	Өлгий сумын төвд шинээр баригдсан 1 км авто зам	18
Зураг 3	Баяннуур сумын 5 дугаар багт баригдсан модон гүүр	18
Зураг 4	Алтай сумын хүүхэд залуучуудын парк	19
Зураг 5	Алтай сумын ерөнхий боловсролын 1 дүгээр сургуулийн халуун ус	19
Зураг 6	Баяннуур сумын хүүхдийн цэцэрлэгийн засвар	20
Зураг 7	Цэцэрлэгүүдэд нийлүүлсэн сэрээ, халбага	21
Зураг 8	Цэцэрлэгүүдэд нийлүүлсэн таваг	23
Зураг 9	Өлгий сумын 29 дүгээр цэцэрлэгийн духоп, гурил зурагч	23
Зураг 10	Өлгий сумын 17 болон 30 дугаар цэцэрлэгүүдийн ногоо хэрчигч	24

### Хавсралтын жагсаалт

№	Тайлбар	Хуудасны дугаар

## Аудитын зорилт, хамарсан хүрээ, стандарт, арга зүйн талаарх мэдэгдэл

### Аудит хийх үндэслэл, бүрэн эрх

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 9 дүгээр зүйлийн 9.1, УИХ-ын Төсвийн байнгын хорооны 2025 оны 25 дугаар тогтоол, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2025 оны “Аудитын жилийн төлөвлөгөө батлах тухай” А/179 дүгээр тушаал, Баян-Өлгий аймаг дахь Төрийн аудитын газрын 2026 онд гүйцэтгэлийн төлөвлөгөөг үндэслэн гүйцэтгэв.

### Аудитын зорилт

Орон нутгийн төсвийн 2025 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүнд гүйцэтгэлийн аудит хийж, дүгнэлт, зөвлөмж боловсруулан дүнг аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурал, Засаг дарга болон холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулахад аудитын зорилго чиглэгдэв. Уг зорилгыг хангахын тулд дараах чиглэлээр аудитыг гүйцэтгэв. Үүнд:

- Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг холбогдох хуульд нийцүүлэн төлөвлөсөн эсэх
- Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг хугацаанд нь гүйцэтгүүлж, хүлээн авсан эсэх
- Хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлсэн төсөл арга хэмжээний санхүүжилтийг шийдвэрлэж, хөрөнгө бүртгэлд тусгасан эсэх

### Аудитын хамарсан хүрээ

Орон нутгийн төсвийн 2025 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүнд хийсэн аудитад аймгийн Засаг дарга түүний харьяа Засаг даргын тамгын газрын Бүс орон нутгийн хөрөнгө оруулалт, бодлого төлөвлөлтийн хэлтэс, Санхүү, төрийн сангийн хэлтэс, Хот байгуулалт, барилга захиалагчийн алба болон холбогдох бусад байгууллага, гүйцэтгэгч аж ахуйн нэгжийг хамруулан төсөл, арга хэмжээний төлөвлөлт, гүйцэтгэгчтэй байгуулсан гэрээ, олгосон санхүүжилт, төсөл, арга хэмжээний хэрэгжилтийг хамруулан хийж гүйцэтгэв.

### Аудитын хязгаарлалт

Байхгүй.

### Аудитын арга зүй, шалгуур үзүүлэлт

Аудитыг гүйцэтгэлийн аудитын стандарт АДБОУС 100, 300, 400, 3000-3100, 4000, Монгол Улсын төрийн аудитын стандарт MNS 6817-5:2020 Гүйцэтгэлийн аудитын зарчим, MNS 6817-5:2020 Гүйцэтгэлийн аудитын зарчим, MNS 6817-6:2020 Нийцлийн аудитын стандарт, “Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам”-ын дагуу аудитын зорилго, зорилт, асуудлын шинжилгээний асуултад хариулт өгөхөд шаардагдах бүх төрлийн нотлох

**Аудитын  
бүрэлдэхүүн,  
хугацаа**

баримтыг цуглуулж, баримтжуулан, тэдгээрийг нягтлан шалгах, дүн шинжилгээ, харьцуулалт, тулган баталгаажуулалт, түүвэрлэлт хийх, судалгаа явуулах арга зүйг ашиглах зэргээр аудитын хөтөлбөр, горим, асуудлын шинжилгээ, нотлох зүйл цуглуулж, ажлын баримт боловсруулж, аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж боловсруулав.

Аудитыг Баян-Өлгий аймаг дахь Төрийн аудитын газрын аудитын менежер, дарга, тэргүүлэх аудиторын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Х.Женисбек чанарын хяналтыг хэрэгжүүлж, хянан удирдаж, ахлах аудитор С.Нурлан, аудитор Р.Баярмаа нар гүйцэтгэв.

Аудитын талбарын ажлыг 04 дүгээр сарын 17-наас 05 дугаар сарын 04-ны хооронд гүйцэтгэж, тайлагнах үе шатны ажлыг 05 дугаар сарын 04-ээс 05 дугаар сарын 11-ны хооронд хийж гүйцэтгэв.

**Хүндрэл бэрхшээл**

Аудитыг богино хугацаанд хэрэгжүүлснээс шалтгаалан төсөл арга хэмжээний хэрэгжилтэд түүвэрлэн аудит хийж гүйцэтгэв.

**А.ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТААР ТӨСӨВЛӨЛТИЙН ШААРДЛАГА ХАНГААГҮЙ ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭГ ТӨЛӨВЛӨСӨН БАЙНА**

**А.1. Төсөл арга хэмжээг аймгийн хөгжлийн жилийн бичигтэй уялдуулан төлөвлөсөн байна**

Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны 12 дугаар сарын 26-ны өдрийн 30 дугаар тогтоолоор Баян-Өлгий аймгийн 2025 оны орон нутгийн төсвийг баталж, 2025 онд 1 удаа тодотгол хийсэн байна.

Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны 09 дүгээр сарын 11-ны өдрийн 58 дугаар тогтоолоор орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар өмнөх оноос үргэлжлэн хэрэгжих 2,542.7 сая төгрөгийн 11, шинээр хэрэгжих 9,093.8 сая төгрөгийн 86, нийт 11,636.5 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 97 төсөл арга хэмжээг тодотгож баталсан байна. /Хүснэгт №1-оор харуулав/

Мөн аймгийн 2024 оны орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн 2,294.8 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 36 төсөл арга хэмжээний 2024 оны үлдэгдэл мөнгийг санхүүжүүлэхээр 1021.2 сая төгрөгийг хавсралтаар баталсан байна.

Хүснэгт №01. Орон нутгийн төсвийн 2025 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөө

(сая төгрөг)

Ангилал	Шилжих		Шинээр эхлэх		Нийт		Хувь /Төсөвт өртгөөр/
	ТАХ	Төсөвт өртөг	ТАХ	Төсөвт өртөг	ТАХ	Төсөвт өртөг	
Орон нутгийн хөрөнгө оруулалт			37	2,579.5	37	2,579.5	22.17%
Их засвар, тохижилт	7	1,021.2	33	5,984.8	40	7,006.0	60.21%
Замын сан	4	1,521.5	16	529.5	20	2,051.0	17.63%
<b>Бүгд</b>	<b>11</b>	<b>2,542.7</b>	<b>86</b>	<b>9,093.8</b>	<b>97</b>	<b>11,636.5</b>	<b>100%</b>

Эх сурвалж: Аймгийн ИТХ-ын тогтоол

Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын нийт төсвийн 22.2 хувийг барилга, байгууламжийн 37, 60.2 хувийг их засвар, тохижилтын 40, 17.6 хувийг замын сангийн 20 төсөл, арга хэмжээнд зарцуулахаар төлөвлөсөн байна.

Хүснэгт №02. Төлөвлөсөн ТАХ төсөвт өртөг, тоон үзүүлэлтийн судалгаа

(сая төгрөг)

№	Төрөл	Шинээр хэрэгжүүлэхээр төлөвлөсөн ТАХ			
		ТАХ	Хувь	Төсөвт өртөг	Хувь
1	Төсөвт өртөг нь 20.0 сая төгрөг хүртэлх ТАХ	41	42.3%	710.90	6.1%
2	Төсөвт өртөг нь 20.0 сая төгрөгөөс дээш үнийн дүнтэй ТАХ	56	57.7%	10925.6	93.9%
	<b>Нийт</b>	<b>97</b>	<b>100%</b>	<b>11,636.5</b>	<b>100%</b>

Эх сурвалж: Аудитын судалгаа

Дээрх хүснэгтэд дурдсан 20.0 сая төгрөг хүртэлх төсөвт өртөгтэй төсөл арга хэмжээг тодотгон харуулбал орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар чухал хэрэгцээ шаардлагатай эсэх нь тодорхой бус зарим төрийн байгууллага болон сургууль, цэцэрлэгүүдэд хатуу, зөөлөн эдлэл, тоног төхөөрөмж худалдан авахад 223.3 сая төгрөгийн 13, зам засварын ажилд 211.5 сая төгрөгийн 11, барилгын засварт 202.0 сая төгрөгийн 12, бусад 74.1 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 5, нийтдээ 710.9 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 41 төсөл арга хэмжээг төлөвлөж батлуулсан нь үр өгөөжтэй хөрөнгө оруулалт болж чадаагүй байна.

Цаашид тендер зохион байгуулахаас зайлсхийж, төсөл, арга хэмжээний зураг төсвийг баталсан төсөвт өртөгт тааруулж хийлгэдэг, гэрээ шууд байгуулах аргаар хэрэгжүүлэх зорилгоор төсөвт өртгийг жижиглэн олон ТАХ болгон төлөвлөдөг зөрчил давтагдаж байгаа явдалд дүгнэлт хийж, хөрөнгө оруулалтыг үр өгөөжтэй төсөл арга хэмжээг төлөвлөхөд анхаарах шаардлагатай байна.

Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 2025 онд шинээр хэрэгжүүлэхээр баталсан 67 төсөл арга хэмжээг хөгжлийн бодлого төлөвлөлтийн баримт бичигтэй нийцсэн эсэхийг шалгахад дараах байдалтай байна. Үүнд:

- ✓ Аймгийн 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, Аймгийн Засаг даргын 2024-2028 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөрт 96 төсөл арга буюу 98.9 хувь нь нийцсэн, 1 төсөл арга хэмжээ буюу 1.1 хувь нь нийцээгүй;

*Хүснэгт №03. Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн судалгаа*

№	Ангилал	ТАХ	Аймгийн 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл		Аймгийн Засаг даргын 2024-2028 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөр	
			нийцсэн	нийцээгүй	нийцсэн	нийцээгүй
1	Орон нутгийн хөрөнгө оруулалт	37	37	0	37	0
2	Их засвар, тохижилт	40	40	0	40	0
3	Замын сан	20	19	1	19	1
	Дүн	97	96	1	19	1

*Эх сурвалж: Аудитын судалгаа*

Дээрх хүснэгтээс харахад хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг аймгийн хөгжлийн бодлого төлөвлөлтийн бодлогын баримт бичигтэй уялдуулан төлөвлөсөн байна.

***А.2. Хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд төсөвлөлтийн шаардлага хангаагүй төсөл, арга хэмжээг тусгаж баталсан байна***

Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны 12 дугаар сарын 26-ны өдөр 30 дугаар тогтоолоор анх баталсан 2025 оны орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар шинээр хэрэгжих 23 төсөл арга хэмжээнд 1,465.0 сая төгрөг, их засварын ажилд шилжих хөрөнгө оруулалтаар 7 төсөл арга хэмжээнд 1,021.2 сая төгрөг, шинээр хэрэгжих 39 төсөл арга хэмжээнд 7,445.5 сая төгрөг, замын санд шилжих хөрөнгө оруулалтаар 4 төсөл арга хэмжээнд 1,521.5 сая төгрөг, шинээр хэрэгжих 17 төсөл арга хэмжээнд 749.2 сая төгрөг нийтдээ 11,181.1 сая төгрөгийг төлөвлөсөн байна.

Тус газраас аймгийн Орон нутгийн 2025 оны төсвийн төсөлд дүгнэлт өгөх аудитаар:

- ✓ Аймгийн ЗДТГ-ын болон Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын мэргэжилтнүүдийг компьютер, тоног төхөөрөмж, тавилга эд хогшлоор хангахад төлөвлөсөн 130.0 сая төгрөг, төрийн байгууллагуудын ажилчдыг компьютер, тоног төхөөрөмж, тавилга эд хогшлоор хангахад төлөвлөсөн 650.0 сая төгрөг, Цэнгэл сумын Соёлын төвд тавилга, эд хогшил, тоног төхөөрөмж нийлүүлэхэд төлөвлөсөн 50.0 сая төгрөг, нийт 830.0 сая төгрөгийн 3 төсөл, арга хэмжээ төлөвлөсөн.
- ✓ Орон нутгийн их засварын хөрөнгөөр 2025 онд шинээр хэрэгжүүлэхээр төлөвлөсөн 6,424.3 сая төгрөгийн 38 төсөл арга хэмжээ нь зураг төсөвгүй, холбогдох баримт бичиг, нотлох баримтаар баталгаажуулаагүй байгаа нь Төсвийн тухай хууль, Төрийн хэмнэлтийн тухай хууль, Засгийн газрын 2023 оны 278 дугаар тогтоолоор баталсан “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам”-ын 3.2.3, 3.2.3.3 дахь заалтуудтай нийцэхгүй байна гэсэн дүгнэлт хийж, дараах саналыг хүргүүлсэн байна. Үүнд:
- ✓ Тавилга, эд хогшил, тоног төхөөрөмж нийлүүлэх 830.0 сая төгрөгийн 3 төсөл, арга хэмжээг хасах.
- ✓ Орон нутгийн их засварын хөрөнгөөр шинээр хэрэгжүүлэхээр төлөвлөсөн 6,424.3 сая төгрөгийн 38 төсөл арга хэмжээг хуульд заасан төсөвлөлтийн шаардлагад нийцүүлэх.

Бүс орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалт, бодлого, төлөвлөлтийн хэлтсээс нь орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар шинээр хэрэгжих төсөл арга хэмжээг аймгийн ИТХ-д оруулж батлуулахаас өмнө хууль, журмын дагуу зураг, төсвөө батлуулсан талаарх нотлох баримтыг аудитад ирүүлээгүй.

Хот байгуулалт, барилга захиалагчийн албанаас хариуцаж хийлгэсэн зураг төсвийн баримт бичгийг, албан тоотоор баримтжуулан хавсралт үйлдэж авах шаардлагатай байна.

*Цаашид орон нутгийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл арга хэмжээг батлахаас өмнө зураг төсвийг хийлгэх, хийсэн төсөл арга хэмжээг баримтжуулах, зөрчлийг давтан гаргахгүй байх талаар зөвлөмж хүргүүлэв.*

Орон нутгийн төсвийн 2025 оны хөрөнгө оруулалтаар тухайн онд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн ТАХ-г аймгийн ЗДТГ-ын Бүс орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалт, бодлого төлөвлөлтийн хэлтсээс хөрөнгө оруулалтын удирдлагын [pimis.publicinvestment.gov.mn](http://pimis.publicinvestment.gov.mn) цахим системээр баталсан журам, аргачлалын дагуу үнэлж, эрэмбэлэн ажилласан байна.

### **А.3. Төлөвлөсөн нийт төсөл арга хэмжээний 92 хувь нь өмчлөлд шилжих хөрөнгө оруулалт байна**

Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 2025 онд өмнөх оноос үргэлжлэн хэрэгжиж буй 2,542.7 сая төгрөгийн 11, шинээр эхлэх 9,093.8 сая төгрөгийн 86, нийт 11,636.5 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 97 ТАХ баталсан байна.

## Хүснэгт №5 Хэрэгжүүлэх ТАХ нь өмчлөлд шилжих эсэхийн судалгаа

(сая төгрөг)

Ангилал	2025 хэрэгжүүлэх ТАХ		Үүнээс: Тухайн шатны төсөвт хамаарах хуулийн этгээдийн өмчлөлд шилжих эсэх /тийм, үгүй/				Өмчлөлд шилжих хувь /төсөвт өртгөөр/
			Тийм		Үгүй		
	ТАХ	Төсөвт өртөг	ТАХ	Төсөвт өртөг	ТАХ	Төсөвт өртөг	
Орон нутгийн хөрөнгө оруулалт	37.0	2,579.5	37.0	2,479.5	1.0	100.0	96 %
Их засвар, тохижилт	40.0	7,005.0	39.0	7,005.0	-		100 %
Замын сан	20.0	2,051.0	3.0	1,221.5	17.0	829.5	60 %
<b>Бүгд</b>	<b>97.0</b>	<b>11,635.5</b>	<b>79.0</b>	<b>10,706.0</b>	<b>18.0</b>	<b>929.5</b>	<b>92 %</b>

Эх сурвалж: Аудитын судалгаа

Дээрх судалгаанаас харахад 929.5 сая төгрөгийн 18 төсөл арга хэмжээ нь тухайн шатны байгууллагын өмчлөлд шилжих боломжгүй төсөл арга хэмжээ байна. Үүнд:

- ✓ Орон нутгийн хөрөнгө оруулалтын Жижиг, дунд үйлдвэрийг дэмжих зээлийн шинээр хэрэгжүүлэх 100.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 1 төсөл арга хэмжээ нь эргэн төлөгдөх нөхцөлттэйгөөр төлөвлөсөн төсөл арга хэмжээ,
- ✓ Замын сангийн хөрөнгө оруулалтаар Толбо-Дэлүүн чиглэлийн авто замын нарийвчилсан зураг төсөл боловсруулах 300.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй шилжих хөрөнгө оруулалтын 1 төсөл арга хэмжээ, 529.5 сая төгрөгийн төсөвт өртөгтэй шинээр хэрэгжүүлэх 16 төсөл арга хэмжээ нь замын сайжруулалттай холбоотой төлөвлөсөн төсөл арга хэмжээ байна.

Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар тухайн шатны төсөвт хамаарах хуулийн этгээдийн өмчлөлд шилжих 10,706.0 сая төгрөгийн 79 төсөл арга хэмжээг төлөвлөсөн байна.

## **Б. ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААГ ЗОХИОН БАЙГУУЛАХАД ТӨРИЙН ХЭМНЭЛТИЙН ТУХАЙ ХУУЛИЙГ ХЭРЭГЖҮҮЛЖ АЖИЛЛААГҮЙ БАЙНА**

### **Б.1 Төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг төлөвлөхдөө хууль журмыг хангалтгүй хэрэгжүүлсэн байна**

Аймгийн Засаг дарга Худалдан авах ажиллагааны газраас боловсруулсан худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг 2025 оны 01 дүгээр сарын 09-ны өдөр баталсан байна.

Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар аймгийн хэмжээнд шинээр хэрэгжүүлэхээр 9,093.8 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 86 ТАХ төлөвлөгдсөнөөс тухайн онд 8,943.8 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 83 ТАХ-д худалдан авах ажиллагаа зохион байгуулсан байна.

Аймгийн Засаг даргын 2025 оны А/08, А/177, А/194, А/232, А/237, А/705 дугаар захирамжуудаар 655.2 сая төгрөгийн 11 ТАХ-г холбогдох төсвийн захирагч нарт эрх шилжүүлсэн байна.

Аймгийн ХААГ-аас 5,909.4 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 9 ТАХ-д нээлттэй, 1,671.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 23 ТАХ-д харьцуулалтын аргаар худалдан авах ажиллагааг зохион байгуулжээ.

Харин 690.9 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 40 ТАХ-д аймгийн Засаг дарга гэрээ шууд байгуулан хэрэгжүүлсэн байна.

Хүснэгт №6 Худалдан авах ажиллагааны зохион байгуулалт

(сая төгрөг)

Тендер шалгаруулалтын арга	БӨ аймгийн ХААГазар (аймгийн Засаг дарга)		Бусад ТШЗ эрх шилжсэн		Нийт ХАА	
	ТАХ	Төсөвт өртөг	ТАХ	Төсөвт өртөг	ТАХ	Төсөвт өртөг
Нээлттэй	9	5,926.70			9	5,926.70
Харьцуулалт	23	1,671.00	11	655.20	34	2,326.20
ШХА	40	690.90			40	690.90
<b>Нийт дүн</b>	<b>72</b>	<b>8,288.60</b>	<b>11</b>	<b>655.20</b>	<b>83</b>	<b>8,943.80</b>

Эх сурвалж: Аудитын судалгаа

Аймгийн Засаг даргын захирамжаар холбогдох төсвийн захирагч нарт эрх шилжүүлсэн 655.2 сая төгрөгийн 11 төсөл арга хэмжээг харьцуулалтын аргаар худалдан авах ажиллагааг зохион байгуулсан байна.

“Хилийн цэргийн 0165 дугаар ангийн төвд “Хил хамгаалалтын удирдлагын төв” барих”, “Хилийн цэргийн 0285 дугаар ангийн заставд гүний худаг гаргах” ТАХ-үүдийг нууцын байгууллагатай холбоотой тул цахим тендер зарлаагүй, үнийн судалгаа хийж худалдан авалтыг хийсэн байна.

Худалдан авах ажиллагааг зохион байгуулсан байдлыг ТАХ-ний тоогоор авч үзвэл нээлттэй тендер шалгаруулалтын аргаар 9 буюу 12.5 хувь, харьцуулалтын аргаар 34 буюу 47.2 хувь, гэрээ шууд байгуулах аргаар 40 буюу 55.6 хувийг зохион байгуулсан байна.

Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжсэн ТАХ-үүдийн ХАА-г зохион байгуулсан төлөвлөж, хэрэгжүүлэхдээ холбоотой зөрчил илэрлээ. Үүнд:

1. Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын нээлттэй тендер шалгаруулалтаар 2, харьцуулалтын тендер шалгаруулалтаар 9, шууд гэрээгээр 8, нийтдээ 1,073.1 сая төгрөгийн 19 төсөл арга хэмжээг үүнээс 780.4 сая төгрөгийн 9 төсөл арга хэмжээг 06 дугаар сарын 07-ны өдрөөс 08 дугаар сарын 01-ны өдөр хүртэл, 292.6 сая төгрөгийн 10 төсөл арга хэмжээг 09 дүгээр сарын 15-ны өдрөөс 11 дүгээр сарын 27-ны өдөр хүртэл хэрэгжүүлэхээр гэрээ байгуулж худалдан авах ажиллагааг тухайн жилийн 05 дугаар сарын 31-ний өдрийн дотор бүрэн дуусгаагүй.

2. Аймгийн ИТХ-ын 2024 оны 12 дугаар сарын 26-ны өдрийн 30 дугаар тогтоолоор 2025 онд шинээр хэрэгжүүлэх 8.638.4 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 78 төсөл арга хэмжээг баталсан ба худалдан авалтын үйл ажиллагааны үр дүнд бий болсон 1,316.4 сая төгрөгийн хөрөнгө оруулалтын төсвийн хэмнэлтийг төсвийн хэмнэлтэд тооцолгүй улмаар аймгийн ИТХ-ын 2025 оны 09 дүгээр сарын 11-ны өдрийн 58 дугаар тогтоолоор шинэ төсөл арга хэмжээ хэрэгжүүлэхээр тодотгосон зөрчил илэрсэн. Уг хэмнэлт нь батлагдсан санхүүжих дүнгээс гэрээний дүнгээр олгосон санхүүжилтийн зөрүү, мөн зарим нэг хэрэгжээгүй төсөл арга хэмжээний санхүүжилтийн хэмнэлт болон орлого тасарсантай холбоотой олгогдоогүй мөнгөн дүнгийн нийлбэр болно.

Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.1.-д “батлагдсан төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг жил бүрийн 05 дугаар сарын 31-ний өдрийн дотор бүрэн дуусгах”, 13.1.2-т “энэ хуулийн 13.1.1-д заасан хугацаанд худалдан авах ажиллагааг зохион байгуулж дуусгаагүй бол төсөл, арга хэмжээний санхүүжилтийг төсвийн хэмнэлтэд тооцох”, 13.1.3-т “хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааны үр дүнд бий болсон хэмнэлтийг зарцуулахгүй байх” гэсэн заалтыг зөрчсөн байна.

3. Нэг ижил төрлийн бараа, ажил үйлчилгээний худалдан авалт хийхдээ тендер шалгаруулалтын журмыг хэрэглэхээс зайлсхийж төсөвт өртгийг хувааж 119.9 сая төгрөгийн гэрээг шууд байгуулж худалдан авсан. Өлгий сумын 17, 29, 30, Цэнгэл сумын 5 дугаар цэцэрлэг, Өлгий сумын 7 дугаар багийн цэцэрлэг, ерөнхий боловсролын сургууль зэрэг 6 байгууллагад гал тогооны тоног төхөөрөмж нийлүүлэх төсөл арга хэмжээг тус бүр 20.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэйгөөр төлөвлөж 4 компанитай шууд худалдан авалтын гэрээ хийж хэрэгжүүлсэн байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1-д “Улс, орон нутгийн төсөв болон захиалагчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авахад энэ хуулийг дагаж мөрдөнө”, 10 дугаар зүйлийн 10.3-д “Захиалагч шууд худалдан авах, харьцуулалтын аргыг хэрэглэх зорилгоор батлагдсан төсөвт өртгийг хувааж худалдан авах ажиллагаа зохион байгуулахыг хориглоно” гэсэн заалтыг зөрчсөн байна.

Аудитын дүнгээр Төрийн хэмнэлтийн тухай хууль болон холбогдох хууль, тогтоомж, журмыг мөрдөж ажиллахыг аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурал, аймгийн Засаг даргад зөвлөмж болгож, зөрчил арилгах 119.9 сая төгрөгийн албан шаардлага өгөв.

### ***Б.2 Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний тендерийн баримт бичиг баримттай холбоотой гомдол гараагүй байна***

Хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээний тендерийн бичиг баримтыг үнэлгээний хорооны нарийн бичгийн дарга (ХААГ-ын мэргэжилтэн) жишиг бичиг баримтыг боловсруулан хорооны хуралдаанаар танилцуулж, гишүүд санал бодлоо солилцож, хэлэлцэн боловсруулан аймгийн Засаг даргаар батлуулан ажилласан байна.

Нээлттэй тендер шалгаруулалт болон харьцуулалтын аргаар зохион байгуулсан 7,580.4 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 32 төсөл арга хэмжээний тендерийн бичиг баримтыг боловсруулж батлуулсан ба тайлант онд тендерийн бичиг баримттай холбоотой гомдол гараагүй байна.

### ***Б.3 Тендер шалгаруулалтын үр дүнг хуулийн хугацаанд бүрэн мэдээлээгүй байна***

Нээлттэй тендер шалгаруулалтын аргаар нийт 5,909.4 сая төгрөгийн 9 ТАХ-ний ХАА-г зохион байгуулахаар төлөвлөсөн боловч 4,909.4 сая төгрөгийн 8 ТАХ-ний ХАА амжилттай болж гэрээ байгуулсан байна. Харин 1,000.0 төгрөгийн төсөвт өртөгтэй “Өвс, тэжээлийн нөөц бүрдүүлэх” ТАХ-ний хувьд 6 багцад хувааж тендер зарласан ба 1-4 дүгээр багц амжилтгүй болж, 5, 6 дугаар багцад тендер шалгаруулалттай холбоотой маргаан гарч шүүхийн шатанд яваагаас гэрээ байгуулаагүй байна.

“Төрийн байгууллагуудыг компьютер, тоног төхөөрөмж, тавилга эд хогшлоор хангах” ТАХ-г анх 650.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэйгөөр төлөвлөж ХАА-г зохион байгуулсан ба 243.0 сая төгрөгийн 1, 4 дүгээр багц амжилгүй болж, 407.0 сая төгрөгийн 2, 3 дугаар багц амжилттай болсон байна. Аймгийн ИТХ-ын 2025 оны 9 дүгээр сарын 11-ний өдрийн 58 дугаар тогтоолоор төсөвт өртгийг амжилттай болсон багцын дүн буюу 407.0 сая төгрөгөөр тодотгосон байна.

“Сагсай сумын Ерөнхий боловсролын 1 дүгээр сургуулийн засвар /аймгийн оролцоо/-ТАХ-ий хувьд тендер шалгаруулалтыг 2 удаа зохион байгуулж гэрээ байгуулсан байна.

Харьцуулалтын аргаар нийт 1,671.0 сая төгрөгийн 23 ТАХ-ний ХАА-г зохион байгуулахаар төлөвлөсөн ба 1,641.0 сая төгрөгийн 22 ТАХ-ний ХАА амжилттай болж гүйцэтгэгчтэй гэрээ байгуулсан байна. Харин 30.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй “Цагааннуур тосгонд цэвэр ус тээвэрлэх машин худалдан авах” ТАХ-ний тендер шалгаруулалтыг 3 удаа зарласан боловч амжилтгүй болсон байна. Харьцуулалтын аргаар зохион байгуулсан 277.0 сая төсөвт өртөгтэй 4 ТАХ-ний ХАА-г тус бүр 2 удаа зарлаж үр дүн гарч гэрээг байгуулсан байна.

Худалдан авах ажиллагааны хэрэгжилт, үр дүнг нийтэлсэн байдлыг цахим системээс шалгаж үзэхэд дараах зөрчил илэрлээ. Үүнд:

- ✓ Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авахдаа захиалагч тендер нээсэн даруй тендер хянан үзэх, үнэлэх ажиллагааг эхлүүлж, тендер нээснээс хойш ажлын 15 өдрийн дотор шийдвэрийг гаргаж хуулийн хугацаандаа цахим системд тендерийн үр дүнг олон нийтэд нээлттэйгээр мэдээлэх ёстой боловч нээлттэй тендер шалгаруулалтын 4 төсөл арга хэмжээний шийдвэрийг 2-101 хонгоор, харьцуулалтын аргар тендер шалгаруулалтын 5 төсөл арга хэмжээний 1-27 хонгоор тус тус хожимдуулж нийтэлсэн байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 24 зүйлийн 24.1-д "Захиалагч тендер нээсэн даруй тендер хянан үзэх, үнэлэх ажиллагааг эхлүүлж, энэ хуулийн 28.1-д заасан шийдвэрийн аль нэгийг тендер нээснээс хойш ажлын 15 өдрийн дотор гаргана" 28 дугаар зүйлд заасан "Захиалагч шийдвэр гаргах, түүнийг мэдэгдэх", 28.1-д "Захиалагч тендер тус бүрд дараах шийдвэрээс аль тохирохыг гаргана", 28.1.1-д "хамгийн сайн тендер ирүүлсэн оролцогчид гэрээ байгуулах эрх олгох", 28.1.2-т "шаардлагад нийцсэн тендер ирүүлсэн боловч хамгийн сайн тендер ирүүлээгүй бусад оролцогчийн тендер шалгараагүй тухай", 28.1.3-т "шаардлагад нийцээгүй тендер ирүүлсэн оролцогчийн тендерээс татгалзах" гэсэн заалтыг зөрчсөн байна.

Аудитын дүнгээр Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль тогтоомж болон холбогдох хууль тогтоомж, журмыг мөрдөж ажиллах, цаашид гарсан зөрлийг давтан гаргахгүй байх талаар аймгийн Засаг даргын тамгын газар, Худалдан авах ажиллагааны газарт зөвлөмж хүргүүлэв.

Аймгийн Худалдан авах ажиллагааны газраас тендер шалгаруулж, гэрээ байгуулах эрх олгосон 3 тендерийн ажлын бичиг баримттай холбоотой оролцогч компаниудаас Сангийн яаманд 2, шүүхэд 1 гомдол гаргасан байна.

Гомдол гаргасан 3 худалдан авах ажиллагааны тендер шалгаруулалтыг ажил тус бүрээр авч үзвэл дараах байдалтай байна. Үүнд:

1. Аймгийн Онцгой байдлын газарт гарааш барих ТАХ-ний тендерт нийт 5 компани материал ирүүлснээс үнэлгээний хороо 2025 оны 06 дугаар сарын 06-ны өдөр аймгийн Засаг даргад "Алтай шар говь" компанийг шалгаруулж гэрээ байгуулах зөвлөмжийг хүргүүлсэн байна. 2025 оны 06 дугаар сарын 25-ны өдөр аймгийн Засаг даргаас тендерт шалгарсан "Алтай шар говь"-д гэрээ байгуулах тухай, шалгараагүй 4 компанид шалгараагүй талаар мэдэгдлийг хүргүүлсэн байна.

Үүнтэй холбоотой оролцогч "Нурбах" ХХК-иас Сангийн яаманд гомдол гаргасан ба Сангийн яамнаас 2025 оны 07 дугаар сарын 03-ны өдрийн 02/6654 дугаар албан бичгээр тус ХАА нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.1, 13.1.2 дахь заалтуудад хамаарах тул санхүүжилтийн эх үүсвэрийг төсвийн хэмнэлтэд тооцож, гэрээ байгуулахгүй байхыг захиалагчид анхааруулсан байна.

Гэтэл 2025 оны 08 дугаар сарын 12-ны өдөр захиалагч "Алтай шар говь" компанитай тус ТАХ-г хэрэгжүүлэхээр гэрээг байгуулсан байна.

2. "Сагсай сумын Ерөнхий боловсролын 1 дүгээр сургуулийн засвар /аймгийн оролцоо/" ТАХ-ний хувьд эхний удаа зарлахад 2 компани саналаа ирүүлсэн ба шалгарсан компани тус тендерээс татгалзсан байна. Журмын дагуу дараагийн компанийг шалгаруулахаар болоход тус ТАХ-г хамтран хэрэгжүүлж байгаа "Өвсний үндэс" хөтөлбөрийн зүгээс тус компанийг шаардлага хангахгүй гэж татгалзсанаар дахин зарласан байна. 2 дахь удаагаа зарлахад 4 компани оролцсон ба Виктори буйлдинг ХХК шалгарсан байна. Саналаа ирүүлсэн Дайчин хүлгүүд ХХК-иас Сангийн яаманд гомдол гарсан ба үүний дагуу үнэлгээг дахин хийх талаар чиглэл ирсэн ба үүний дагуу дахин үнэлж Виктори буйлдинг ХХК шалгарсан байна..

3. Өвс, тэжээлийн нөөц бүрдүүлэх" ТАХ-ний хувьд 6 багцад хувааж тендер зарласан ба тэжээлийн 1-4 дүгээр багц амжилтгүй болж, өвсний 5, 6 дугаар багцад тендер шалгаруулалттай холбоотой гомдол гарч шүүхийн шатанд маргаантай байна.

Дээрх байдлаас дүгнэж үзэхэд аймгийн Худалдан авах ажиллагааны газраас тендер шалгаруулалттай холбоотой маргаан жил бүр давтагдан гарч буй байдалд дүгнэлт хийж, хууль журмыг мөрдөж ажиллахад анхаарч ажиллах шаардлагатай байна.

## **В.ЗАРИМ ТӨСӨЛ АРГА ХЭМЖЭЭГ ЗУРАГ ТӨСВИЙН ДАГУУ БҮРЭН ХИЙГЭЭГҮЙ БАЙХАД АШИГЛАЛТАД ХҮЛЭЭН АВСАН БАЙНА**

### **В.1. Төсөл арга хэмжээг гүйцэтгэлийн дагуу санхүүжүүлж, гэрээг дүгнэсэн байна**

Аймгийн орон нутгийн 2025 оны төсвийн хөрөнгө оруулалтын нийт 8,658.3 сая төгрөгийн санхүүжих дүнгээс 6,391.4 сая төгрөгийн санхүүжилтийг олгосон байна. Үүнд:

- ✓ Орон нутгийн төсвийн хөрөнгөөр 2025 онд шинээр хийгдэх болон шилжих 97 төсөл арга хэмжээнд 7,637.2 сая төгрөгийн санхүүжилтийг олгохоор баталснаас гүйцэтгэлээр 69 төсөл арга хэмжээнд 5,572.5 сая төгрөгийн санхүүжилт олгосон нь батлагдсан төсвийн 72.9 хувийг эзэлж байна. /Хүснэгт №7-оор харуулав/
- ✓ Өмнөх 2024 оны үлдэгдэл мөнгийг санхүүжүүлэхээр 36 төсөл арга хэмжээнд 1021.2 сая төгрөгийг баталж, гүйцэтгэлээр 818.8 сая төгрөгийг зарцуулсан байна.

Хүснэгт №7 2025 онд шилжих буюу шинээр хэрэгжих ТАХ-ний санхүүжилтийн судалгаа

(сая төгрөг)

№	Ангилал	Шилжих ТАХ /Өмнөх оноос хэрэгжсэн/				Шинэ ТАХ /2025 онд шинээр хэрэгжсэн/				Бүгд дүн			
		ТАХ	Санхүүжих	ТАХ	Санхүүжсэн	ТАХ	Санхүүжих	ТАХ	Санхүүжсэн	ТАХ	Санхүүжих	ТАХ	Санхүүжсэн
1	Орон нутгийн хөрөнгө оруулалт	-	-	-	-	37	1,453.0	28	1,156.6	37	1,453.0	28	1,156.6
2	Их засвар, тохижилт	7	193.9	6	155.6	33	4,808.3	24	3,353.1	40	5,002.2	30	3,508.7
3	Замын сан	4	791.5	4	727.8	16	390.5	7	179.4	20	1,182.0	11	907.2
	<b>Нийт дүн</b>	<b>11</b>	<b>985.4</b>	<b>10</b>	<b>883.4</b>	<b>86</b>	<b>6,651.8</b>	<b>59</b>	<b>4,689.1</b>	<b>97</b>	<b>7,637.2</b>	<b>69</b>	<b>5,572.5</b>

Эх сурвалж: Аудитын судалгаа

Өмнөх оноос дамжин хэрэгжсэн 11 төсөл арга хэмжээнд 985.4 сая төгрөгийг олгохоор баталж, гүйцэтгэлээр 10 төсөл арга хэмжээнд 883.4 сая төгрөг буюу 86.6 хувийн санхүүжилт олгосон. Шинээр хэрэгжих 86 төсөл арга хэмжээнд 6,651.8 сая төгрөгийг олгохоор баталж, гүйцэтгэлээр 59 төсөл арга хэмжээнд 4,689.1 сая төгрөг буюу 70.5 хувийн санхүүжилт олгосон байна.

Баталсан санхүүжих дүнгээс орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын 9 төсөл арга хэмжээний 296.4 сая төгрөгийн, их засвар, тохижилтын 10 төсөл арга хэмжээний 1,493.8 сая төгрөгийн, замын сангийн 9 төсөл арга хэмжээний 274.8 сая төгрөгийн санхүүжилт тус тус олгогдоогүй байна.

Энэ нь батлагдсан санхүүжих дүнгээс гэрээний дагуу олгосон санхүүжилтийн зөрүү, зарим нэг хэрэгжээгүй төсөл арга хэмжээний санхүүжилтийн хэмнэлт болон орон нутгийн төсвийн орлого тасарсантай холбоотой олгогдоогүй мөнгөн дүнгийн нийлбэр юм.

Захиалагчийн техник хяналтын зардалд 60.3 сая төгрөг, зохиогчийн хяналтын зардалд 5.5 сая төгрөг, зураг, төсвийн зардалд 139.6 сая төгрөг, нормын зардлын зардалд 1.3 сая төгрөг бүгд 206.7 сая төгрөгийн санхүүжилт олгосон нь нийт санхүүжсэн дүнгийн 3.7 хувийг эзэлсэн байна.

Тайлант онд хэрэгжсэн төсөл, арга хэмжээнүүдийн санхүүжилтийг ажлын гүйцэтгэлд үндэслэн олгож, хэрэгжиж дууссан төсөл арга хэмжээнүүдийн гэрээг журмын дагуу дүгнэсэн байна.

**В.2. Зарим төсөл арга, хэмжээг зураг төсөө, техникийн тодорхойлолтын дагуу гүйцэтгээгүй, хяналтыг хангалтгүй хэрэгжүүлсэн байна**

Аймгийн Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 2025 онд хэрэгжих 11,636.5 сая төгрөгийн төсөвт өртөгтэй, 10,393.5 сая төгрөгийн санхүүжих дүнтэй 97 ТАХ-г хэрэгжүүлэхээр баталсан.

Хүснэгт №8 Гэрээ байгуулсан төсөл арга хэмжээний хэрэгжилтийн судалгаа

(тоогоор)

Ангилал	Гэрээ байгуулсан ТАХ	Үүнээс		
		Он дамжин хэрэгжих ТАХ	Хэрэгжиж дуссан ТАХ	Хэрэгжээгүй буюу хэрэгжилт дутуу ТАХ
		Тоо	Тоо	Тоо
<b>Орон нутгийн хөрөнгө оруулалт</b>	35	-	35	-
<b>Их засвар, тохижилт</b>	40	1	39	0
<b>Замын сан</b>	19	-	18	1
<b>Нийт</b>	<b>94</b>	<b>1</b>	<b>92</b>	<b>1</b>

Эх сурвалж: Аудитын судалгаа

Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 10,393.5 сая төгрөгийн гэрээний дүнтэй 94 төсөл арга хэмжээг хэрэгжүүлэхээр гэрээ байгуулснаас 7,576.5 сая төгрөгийн гэрээний дүнтэй 92 төсөл арга хэмжээ хэрэгжиж, 2,798.0 сая төгрөгийн гэрээний дүнтэй 1 төсөл арга хэмжээ он дамжин хэрэгжиж байгаа ба 19.0 сая төгрөгийн гэрээний дүнтэй 1 төсөл арга хэмжээний хэрэгжилт дутуу байна.

Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжсэн төсөл арга хэмжээг өмнөх оноос шилжин хэрэгжсэн болон шинээр хэрэгжих 10,393.5 сая төгрөгийн гэрээний дүнтэй төсөл арга хэмжээнд аймгийн ЗДТГ-ын Бүс, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалт, бодлого, төлөвлөлтийн хэлтэс, Хот байгуулалт, барилга захиалагчийн алба болон эрх шилжүүлсэн хөрөнгө оруулалтын хувьд сумын ЗДТГ /Алтай, Дэлүүн, Сагсай сумуудын ЗДТГ/ зэрэг байгууллагууд захиалагчийн хяналтыг хэрэгжүүлсэн байна.

Хот байгуулалт, барилга захиалагчийн алба нь аймгийн Засаг даргатай 2025 оны 08 дугаар сарын 01-ны өдөр “Барилга, байгууламжийн ажилд захиалагчийн техникийн хяналтыг гүйцэтгүүлэх” гэрээ байгуулж, нийт 8,035.3 сая төгрөгийн гэрээний дүнтэй 54 төсөл арга хэмжээнд захиалагчийн хяналтыг хэрэгжүүлсэн байна.

Хот байгуулалт барилга, захиалагчийн албад захиалагчийн хяналтын зардалд 60.3 сая төгрөгийн санхүүжилт олгосон байна.

Захиалагч байгууллагууд ТАХ-нд ашиглалтад хүлээн авсан боловч дараах төсөл арга хэмжээнүүдэд хяналтыг хангалтгүй хэрэгжүүлсэн байна. Үүнд:

- ✓ Алтай сумын Хүүхэд, залуучуудын паркийн засварын ажлыг тус сумын Засаг даргын захирамжаар барилга, байгууламжийг ашиглалтад оруулах комисс 2026 оны 11-р сарын 20-ны өдөр хүлээн авч, 47.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй төсөл арга хэмжээг ашиглагч байгууллага данс бүртгэлд тусгасан боловч зураг төсвийн дагуу бүрэн хийгээгүй,
- ✓ Алтай сумын ерөнхий боловсролын 1 дүгээр сургуулийн халуун усны засварын ажлыг сумын Засаг даргын захирамжаар барилга, байгууламжийг ашиглалтад оруулах комисс 2025 оны 08-р сарын 11-ны өдөр ашиглалтад оруулсан боловч зураг төсөвт тусгагдсан 4.6 сая төгрөгийн ажлыг дутуу хийсэн.
- ✓ Алтай сумын соёлын төвийн засвар ажлыг сумын Засаг даргын захирамжаар барилга, байгууламжийг ашиглалтад оруулах комисс 2025 оны 08-р сарын 12-ны өдөр хүлээн авч, 74.7 сая төгрөгийн төсөвт өртөгтэй төсөл арга хэмжээний дутуу хийсэн ажлыг нөхөж хийх боломжгүй 2 сая төгрөгийн,

- ✓ Алтай сумын Эрүүл мэндийн төвийн засварын сумын Засаг даргын захирамжаар барилга, байгууламжийг ашиглалтад оруулах комисс 2025 оны 09-р сарын 10-ны өдөр хүлээн авч, 90.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй төсөл арга хэмжээний дутуу хийсэн ажлыг нөхөж хийх боломжгүй 1 сая төгрөгийн,
- ✓ “Баяннуур сумын Ахуй үйлчилгээний барилгыг цэцэрлэгийн зориулалттай болгон засварлах” 2024 онд 300.0 сая төгрөгийн, 2025 онд 396.3 сая төгрөгийн төсөвт өртөгтэйгөөр хэрэгжсэн төсөл арга хэмжээг ашиглалтад оруулах комиссын дүгнэлт 2025.04.03-ны өдөр, 2025.12.18-ны өдөр баталгаажсан бөгөөд засварын ажлын хэрэгжилтийг шалгаж үзэхэд зураг төсөвт тусгагдсан ажил бүрэн хийгдээгүй, захиалагч болон зохиогч, ажлын хэсгийн хяналтаар өгсөн үүрэг даалгаврыг биелүүлээгүй, барилга байгууламж нь эрүүл ахуйн шаардлага хангахгүй, хэрэгжилт хангалтгүй, төсөвт тусгагдсан 0.8 сая төгрөгийн цахилгаан үүсгүүрийг дутуу нийлүүлсэн байна.
- ✓ Ногооннуур сумын Ховд багийн салбар бүлэг цэцэрлэгийн засварын ажилд хяналт хийсэн ажлын хэсгийн хуралдааны тэмдэглэлээр өгсөн үүрэг даалгаврыг хэрэгжүүлсэн эсэх нь тодорхойгүй, биелэлт ирүүлсэн үнэлж дүгнэсэн талаар нотлох баримтгүй байхад ажлын хэсэг 2025.12.12-ны өдөр ашиглалтад хүлээн авсан байна.

Аудитын дүнгээр захиалагчийн хяналтыг үр дүнтэй хэрэгжүүлж ажиллахыг аймгийн Засаг дарга, Бүс орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалт, бодлого, төлөвлөлтийн хэлтэс, Хот байгуулалт, барилга захиалагчийн албад зөвлөмж болгов.

### **В.3. Зарим төсөл, арга хэмжээг зориулалтын дагуу, бүрэн хүчин чадлаар ашиглаагүй байна**

Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын санхүүжилтээр 2025 онд шинээр болон он дамжин хэрэгжсэн 6,862.7 сая төгрөгийн гэрээний үнийн дүнтэй 83 ТАХ-г эрх бүхий байгууллагуудын шийдвэрээр (захирамж, тушаал) томилогдсон комисс акт үйлдэж хүлээн авч, ашиглалтад оруулсан байна.

#### **Барилга байгууламж:**

Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 2025 онд болон 2024 оноос дамжин хэрэгжсэн нийт 1,448.1 сая төгрөгийн гэрээний дүнтэй 9 барилга байгууламжийн төсөл арга хэмжээг ашиглалтад хүлээн авсан байна. Үүнд: Онцгой байдлын газрын авто машины гарааш барих, Цагааннуур тосгоны төвийн хатуу хучилттай авто зам болон сургууль, цэцэрлэг руу явах замын дагуу явган хүний зам тавих, Гаалийн газрын Цагааннуур боомтод халуун ус, саун барих, Хилийн цэргийн 0165 дугаар ангийн төвд "Хил хамгаалалтын удирдлагын төв" барих, Хилийн цэргийн 0285 дугаар ангийн заставд гүний худаг гаргах зэрэг барилга байгууламжийн 206.7 сая төгрөгийн 5, авто зам, гүүрний байгууламжийн 1,240.5 сая төгрөгийн 4 төсөл арга хэмжээ хэрэгжсэн байна.

Зарим төсөл арга хэмжээний хэрэгжилттэй газар дээр нь танилцахад ОНТХО-аас 87.7 сая төгрөгөөр санхүүжүүлсэн (нийт 195.6 сая төгрөгийн төсөвт өртөгтэй, зөрүүг ОБЕГ-аас эрх шилжүүлсэн) Онцгой байдлын газрын гарааш зураг төсөвт тусгагдсаны дагуу хийгдсэн, хэрэгцээ шаардлагад нийцсэн, ач холбогдолтой төсөл арга хэмжээ байна. Мөн Өлгий сумын төвд шинээр хэрэгжсэн 998.2 сая төгрөгийн 1 км авто замын барилгын ажил нь үр дүнтэй бүтээн байгуулалтын ажил болсон байна.



Зураг №1 Онцгой байдлын газрын гарааш



Зураг №2 Өлгий сумын төвд шинээр баригдсан 1 км авто зам

**Их засвар:**

Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар нийт 4,282.3 сая төгрөгийн 50 их засварын ажлыг ашиглалтад хүлээн авсан ба үүний 3,969.6 сая төгрөгийн 40 ажил барилгын засвар, 312.7 сая төгрөгийн 10 ажил зам, гүүрний засварын ажил байна.

Дээрх төсөл арга хэмжээнүүдийн хэрэгжилттэй танилцахад Баяннуур сумын 5 дугаар багийн 7 га талбайд хийсэн 18.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй гүүрний засварын ажил нь гүүрээр сумын иргэдийн машин, мотоциклоор аюулгүй зорчих боломжийг бүрдүүлсэн, ногооны талбайгаасаа ногоо ачиж зах зээлд нийлүүлэх, ахуйн хэрэгцээнд ач холбогдолтой ажил болсон байна.



**Зураг №3 Баяннуур сумын 5 дугаар багт баригдсан модон гүүр**

Харин 2024 оноос дамжин хэрэгжсэн аймгийн ХДТ-ын 365.0 сая төгрөгийн засварын ажлын хувьд: Үзэгчдийн танхимд байрлуулах сандал стандарт бус, кино театрын зориулалттай сандал ирснээс 40 сандал багтаагүй тул өөр өрөөнд хураасан, дотор заслын танхимын таазанд наасан эсгийн наалт зарим газар салсан, агаар сэлгэх пушкийг хааснаас агаар сэлгэлт хийгдэхгүй байгаа, гэрэлтүүлэг муу гэсэн тайлбарыг ашиглагч байгууллагаас өгсөн.

Төсөл арга хэмжээний төлөвлөсөн үр дүнд хүрсэн эсэхийг газар дээр нь очиж танилцахад дараах зөрчлүүд илэрлээ. Үүнд:

- ✓ Алтай сумын Хүүхэд, залуучуудын паркийн засварын ажлыг тус сумын Засаг даргын захирамжаар томилсон барилга, байгууламжийг ашиглалтад оруулах комисс 2026 оны 11-р сарын 20-ны өдөр хүлээн авсан боловч зураг төсвийн дагуу бүрэн хийгдээгүй,
- ✓ Алтай сумын ерөнхий боловсролын 1 дүгээр сургуулийн халуун усны засварын ажлыг сумын Засаг даргын захирамжаар барилга, байгууламжийг ашиглалтад оруулах комисс 2026 оны 08-р сарын 11-ны өдөр ашиглалтад оруулсан боловч зураг төсөвт тусгагдсан 4.6 сая төгрөгийн ажил дутуу хийгдсэн байна.



**Зураг №4 Алтай сумын хүүхэд залуучуудын парк**




**Зураг №5 Алтай сумын ерөнхий боловсролын 1 дүгээр сургуулийн халуун ус**

- ✓ “Баяннуур сумын Ахуй үйлчилгээний барилгыг цэцэрлэгийн зориулалттай болгон засварлах” 2024 онд 300.0 сая төгрөгийн, 2025 онд 396.3 сая төгрөгийн төсөвт өртөгтэйгээр хэрэгжсэн төсөл арга хэмжээг ашиглалтад оруулах комиссын дүгнэлт 2025 оны 04-р сарны 03-ны өдөр, 2025 оны 12-р сарны 18-ны өдөр тус тус баталгаажсан байна. Засварын ажлын гүйцэтгэл,

хэрэгжилтийг шалгаж үзэхэд зураг төсөвт тусгагдсан ажил бүрэн хийгдээгүй, захиалагч болон зохиогч, ажлын хэсгийн хяналтаар өгсөн үүрэг даалгаврыг биелүүлээгүй, төсөвт тусгагдсан 0.8 сая төгрөгийн цахилгаан үүсгүүрийг дутуу нийлүүлсэн, агааржуулалт байхгүй эрүүл ахуйн шаардлага хангахгүй, (засварын ажил гүйцэтгэхэд өмнө байсан агааржуулалтын нүхнүүдийг хаасан), анги танхимын тааз нь зарим хэсэгт хөгцөрсөн, зарим цонх, тавцангууд хагарч цуурсан (зохиогчийн болон ажлын хэсгийн хяналтаар хагарсан цонх, тавцангуудыг солих талаар үүрэг өгч байсан), дээврийн засварыг зургийн дагуу бүрэн хийгээгүй, төмөр хуулгаснаас тавьсан чулуунууд хүүхдийн аюулгүй байдлыг хангаагүй, хэрэгжилт хангалтгүй байна. Зураг төсөвт тусгагдсан боловч ажлын явцад хийгдэх шарлагагүй болж хэмнэгдсэн (барилгын хуучин бохирын цооног олдсоноос шинэ цооног гаргах шаардлагагүй болсон, гүний худаг гаргах боломжгүй болсон) нийт 57.6 сая төгрөгийн төсвөөр гадна тохижилтын ажил хийлгэхээр зураг төсвийг боловсруулсан боловч тохижилтын ажил бүрэн хийгдээгүй байна.

Тус төсөл арга хэмжээний хувьд 2024 онд заслын ажил, 2025 онд цахилгаан, сантехник, далд ажлуудыг гүйцэтгэхээр төлөвлөснөөс өмнөх онд хийгдсэн заслын ажлууд эвдрэх дахин засварлах шаардлага гарч үр ашиггүй зардал гарсан байна.



Зураг №6 Баяннуур сумын хүүхдийн цэцэрлэгийн засвар

- ✓ Ногооннуур сумын Ховд багийн салбар бүлэг цэцэрлэгийн засварын ажлыг комисс 2025 оны 12-р сарын.12-ны өдөр ашиглалтад хүлээн авсан боловч хяналт хийсэн ажлын хэсгийн хуралдааны тэмдэглэлээр өгсөн үүрэг даалгаврыг хэрэгжүүлсэн эсэх нь тодорхойгүй, биелэлт ирүүлсэн, үнэлж дүгнэсэн талаар баримт материал байхгүй, тухайн төсөл арга хэмжээ зураг төсвийн дагуу бүрэн хэрэгжсэн нотлох баримт байхгүй байна.

Аудитын дүнгээр дээрх төсөл арга хэмжээнүүдийн хангалтгүй болон дутуу хийгдсэн ажлыг бүрэн хийлгэж, гүйцэтгэлд хяналт тавьж ажиллах, дутуу нийлүүлсэн хөрөнгийг компаниас нийлүүлэх талаар Алтай суманд хэрэгжсэн төсөл арга хэмжээний хувьд тус сумын Засаг даргад 51.6 сая төгрөгийн, Баяннуур, Ногооннуур суманд хэрэгжсэн төсөл арга хэмжээний хувьд аймгийн Засаг дарга, Бүс орон нутгийн, төсвийн хөрөнгө оруулалт, бодлого төлөвлөлтийн хэлтэст зөрчил арилгах албан шаардлага хүргүүлэв.

Алтай сумын ерөнхий боловсролын 1 дүгээр сургуулийн халуун усны засварын ажлаас 10.0 сая төгрөгийн ажлыг дутуу хийсэн ба нөхөж хийх боломжгүй 5.6 сая төгрөгийн, Соёлын төвийн засварын ажлаас нөхөж хийх боломжгүй 2 сая төгрөгийн, Эрүүл мэндийн төвийн засварыг ажлаас нөхөж хийх боломжгүй 1 сая төгрөгийн ажилд бүгд 8.6 сая төгрөгийн зөрчлийг гүйцэтгэгч компаниар нөхөн төлүүлэх 8.5 сая төгрөгийн төлбөрийн акт тогтоов.

#### *Тоног төхөөрөмж:*

Тоног төхөөрөмж худалдан авах нийт 864.4 сая төгрөгийн төсөвт өртөгтэй, 813.2 сая төгрөгийн гэрээний дүнтэй 20 төсөл арга хэмжээ хэрэгжсэн байна.

Дээрх төсөл арга хэмжээнүүдийн хэрэгжилтийг түүвэрчлэн газар дээр нь техникийн тодорхойлолт, чанарын шаардлага хангаж байгаа эсэх, бүрэн хүчин чадлаар ашиглаж байгаа эсэхийг шалгаж үзэхэд дараах зөрчлүүд илэрлээ. Үүнд:

- ✓ Өлгий сумын 29 дүгээр цэцэрлэгт нийлүүлсэн 300 ширхэг, 30 дугаар цэцэрлэгт нийлүүлсэн 300 ширхэг, Цэнгэл сумын 5 дугаар цэцэрлэгт 200 ширхэг, нийт 1.2 сая төгрөгийн 800 ширхэг халбага сэрээ нь "цэцэрлэгийн хүүхдийн бариулын хэв маягт тохирсон, эрүүл ахуйн шаардлага хангасан, хурц ирмэггүй.." байх гэсэн техникийн тодорхойлолтыг хангахгүй, сэрээнүүдийг ашиглах боломжгүйгээс агуулахад хураасан, халбагануудыг аргагүй байдлаас үүдэн заримыг нь ашиглаж байгаа байдалтай байна.



*Зураг №7 Цэцэрлэгүүдэд нийлүүлсэн сэрээ, халбага*

Дээрх цэцэрлэгүүдэд нийлүүлсэн 2.7 сая төгрөгийн 400 ширхэг хүүхдийн хоолны иж бүрдлийн таваг нь том хэмжээтэй, нэг ширээнд 6 ширхгээс илүү тавих боломжгүйгээс зарим цэцэрлэгүүд ашиглаагүй байна.



Зураг №8 Цэцэрлэгүүдэд нийлүүлсэн таваг

- ✓ Өлгий сумын 29 дүгээр цэцэрлэгт нийлүүлсэн тоног төхөөрөмжөөс 1.3 сая төгрөгийн гурил зуурагч, 1.6 сая төгрөгийн духов зэрэг тоног төхөөрөмжүүд нь 380вт-ын хүчин чадлаар ажилладаг ба цэцэрлэгийн түрээсэлж байгаа байр нь тухайн хүчин чадлын цахилгааны үүсгүүргүй байгаагаас ашиглаагүй складанд хураалттай байна.



Зураг №9 Өлгий сумын 29 дүгээр цэцэрлэгийн духов, гурил зурагч

- ✓ Цэнгэл сумын 5 дугаар цэцэрлэгт нийлүүлсэн 1.4 сая төгрөгийн 1 дүгээр хоолны тогоо ажиллахгүй (ашиглагчийн зүгээс анх хүлээн авахад ажиллахгүй байсан гэсэн тайлбарыг өгсөн) байгаагаас ашиглах боломжгүй, агуулахад хураасан, Өлгий сумын 30 дугаар цэцэрлэгт нийлүүлсэн 2.0 сая төгрөгийн ногоо хэрчигч, арилгагч төхөөрөмж 30кг-аас дээш ногоог арилгаж, хэрчдэг (техникийн тодорхойлолтод 15кг гэж заасан) түүнээс бага хэмжээний ногоо хийхэд ажилладаггүйгээс мөн л ашиглаагүй агуулахад хураасан байдалтай байна. Өлгий сумын хүүхдийн 17 дугаар цэцэрлэгт "хүчдэл 220В, эрчим хүч 0.75квт, багтаамж 15кг, хэмжээ 570x535x905" үзүүлэлттэй ногоо хэрчигч нийлүүлэхээр техникийн тодорхойлолтод заасан боловч механик жижиг оврын гар хэрчигч 0.8 сая төгрөгийн үнэлгээтэйгээр нийлүүлсэн байна.



Зураг № 10 Өлгий сумын 17 болон 30 дугаар цэцэрлэгүүдийн ногоо хэрчигч

- ✓ Өлгий сумын 17, 29, 30, Цэнгэл сумын 5 дугаар цэцэрлэг, Өлгий сумын 7 дугаар багийн цэцэрлэг, ерөнхий боловсролын сургууль зэрэг 6 байгууллагад нийлүүлсэн гал тогооны тоног төхөөрөмжийн техникийн тодорхойлолт дахь үзүүлэлт, нийлүүлсэн үнийг харьцуулан үзэхэд харилцан адилгүй байна. Жишээ нь: 1-р хоолны тогоо нэг бүрийн үнэ 0.8-2.8 сая төгрөг, 2-р хоолны тогоо нэг бүрийн үнэ 1.0-4.2 сая, ногоо хэрчигч 0.8-2.0 сая төгрөг, цахилгаан плитк 1.2-2.5 сая төгрөг, аяга таваг ариутгагч 1.2-2.4 сая төгрөг байгаа нь тоног төхөөрөмжийн техникийн тодорхойлолт дахь үзүүлэлт, үнийг үндэслэлгүй тооцон хүлээн авч байгааг харуулж байна.

Хүснэгт №9 Цэцэрлэгүүдэд нийлүүлсэн тоног төхөөрөмжийн техникийн тодорхойлолт, үнийн харьцуулсан судалгаа

/мянган төгрөг/

№	Тоног төхөөрөмжийн нэр	Өлгий сумын 17 дугаар цэцэрлэг		Өлгий сумын 30 дугаар цэцэрлэг		Цэнгэл сумын 5 дугаар цэцэрлэг		Өлгий сумын 7 дугаар багийн цэцэрлэг		Өлгий сумын 7 дугаар багийн сургууль	
		Оргил алтайн хулгүүд транс ХХК 3082385		"Атик" ХХК		"Атик" ХХК		"Тансаг холдинг" ХХК 3080854		"Өлгий Буянт" ХХК 3070123	
		Үзүүлэлт	Үнэ	Үзүүлэлт	Үнэ	Үзүүлэлт	Үнэ	Үзүүлэлт	Үнэ	Үзүүлэлт	Үнэ
1	1-р хоолны тогоо	1-р хоолны халуун ажиллагааг гүйцэтгэх зориулалттай, усан цамц уур гаргагчтай, хэмжээ-60л	2,800.0	1-р хоолны халуун ажиллагааг гүйцэтгэх зориулалттай, усан цамц уур гаргагчтай, хэмжээ-60л	1,450.0	1-р хоолны халуун ажиллагааг гүйцэтгэх зориулалттай, усан цамц уур гаргагчтай, хэмжээ-60л	1,350.0			Хэмжээ 641x1015x1030 мм, 60 л багтаамжтай, ган лист материалта	800.0
2	2-р хоолны тогоо	2-р хоолны халуун ажиллагааг гүйцэтгэх зориулалттай, усан цамц уур гаргагчтай, хэмжээ-60л	2,800.0	2-р хоолны халуун ажиллагааг гүйцэтгэх зориулалттай, усан цамц уур гаргагчтай, хэмжээ-60л	2,000.0			Хэмжээ:40 литр Материал: Зэвэрдэггүй ган материалтай байх шаардлагатай Өнгө: Саарал	4,200.0	Хэмжээ 1370x800x960 мм, 70 л багтаамжтай, ган лист материалтай	1,000.0
3	Ногоо хэрчигч	хүчдэл 220В, эрчим хүч 0.75квт, багтаамж 15кг, хэмжээ 570x535x905	800.0	хүчдэл 220В, эрчим хүч 0.75квт, багтаамж 15кг, хэмжээ	2,000.0			30 кг/ц багтаамжтай	1,700.0		
4	Цахилгаан плитк /духов/			хүчдэл:380, эрчим хүч-17квт, багтаамж 4ширэмт,220кг,955x860x880мм	1,200.0	хүчдэл:380, эрчим хүч-17квт, багтаамж 4ширэмт,220кг,955x860x880мм	1,150.0	Хэмжээ: 4 нүдтэй Өнгө: Цагаан	1,500.00	Хэмжээ 50x50x60	2,500.00

Эх сурвалж: Аудитын судалгаа

Аудитын дүнгээр дээрх техникийн тодорхойлолт дах шаардлагыг хангахгүй, бүрэн хүчин чадлаар ашиглагдахгүй байгаа тоног төхөөрөмжүүдийг тухайн гүйцэтгэгч компаниудаар солиулах, ашиглалтад оруулах, боловсролын байгууллагуудад нийлүүлэх тоног төхөөрөмжийн техникийн тодорхойлолтыг нэгэн жишигт нийцүүлж, үнийн дүнг бодитой тооцож хүлээн авах, зөрчлийг арилгах талаар аймгийн ЗДТГ-т албан шаардлага хүргүүлэв.

#### **В.4. Хөрөнгө оруулалтын үр дүнд бий болсон хөрөнгийг ашиглагч байгууллагууд бүртгэлд бүрэн тусгаагүй байна**

Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын санхүүжилтээр 2025 онд шинээр болон он дамжин хэрэгжсэн 6,862.7 сая төгрөгийн гэрээний үнийн дүнтэй 83 ТАХ-г эрх бүхий байгууллагуудын шийдвэрээр (захирамж, тушаал) томилогдсон комисс тухай бүрд нь акт үйлдэж холбогдох байгууллагуудад хүлээлгэн өгсөн байна.

Дээрх хүлээлгэж өгсөн төсөл арга хэмжээнээс 6,052.0 сая төгрөгийн гэрээний дүнтэй 69 ТАХ-ний үр дүнгээр бий болсон хөрөнгийг холбогдох байгууллагууд орлого авч, данс бүртгэлд тусгасан байна.

Харин 232.7 сая төгрөгийн 2 ТАХ-г тухайн байгууллагууд нь данс бүртгэлд тусгаагүй, Үүнд:

- ✓ "Онцгой байдлын газарт автомашины гарааш барих" ТАХ-ий хувьд нийт 195.6 сая төгрөгийн гэрээний дүнтэй ба үүний 87.7 сая төгрөгийг ОНХО-аас санхүүжүүлсэн байна. (Тус ТАХ-г 2025.12.31-ий өдөр улсын комисс хүлээн авсан ба гараашийн халаалтын зардал төсөвт суугаагүй байсныг 2026 оны төлөвлөгөөнд тусгаж, нэмэлт гэрээ байгуулж гүйцэтгүүлсэн байна). Ашиглагч байгууллагын зүгээс Төрийн өмчийн тооллого явагдахтай холбоотой төвөөс өгсөн чиглэлийн дагуу одоогоор бүртгэлд тусгаагүй байгаа гэсэн тайлбарыг өгсөн.
- ✓ Алтай сумын 5 дугаар багийн Мухар даваатын амны Сагсай голд баригдах Хар Мудаагийн модон гүүрийг барилга байгууламжийг ашиглалтад оруулах ажлын хэсгийн 2025.01.13-ны өдрийн 13 дугаар актаар хүлээн ба ашиглагч байгууллага бүртгэлд тусгаагүй байна.

Аудитын дүнгээр данс бүртгэлд тусгаагүй дээрх хөрөнгийг орлогод авч бүртгэх талаар албан шаардлага хүргүүлэв.

Урсгал засварын шинжтэй шороон зам засвар, замын зураг төсөв хийх, бусад нийт 677.9 сая төгрөгийн 11 төсөл арга хэмжээг бүртгэлд тусгах шаардлагагүй тул бүртгээгүй байна. Үүнд:

- ✓ Зам (шороон) зам болон урсгал засварын ажлын 10 төсөл арга хэмжээнд 259.0 сая төгрөг;
- ✓ Авто замын зураг төсөл боловсруулах 2 төсөл арга хэмжээнд 319.0 сая төгрөг;
- ✓ ХХААХҮС-ын 2025 оны А/94 дүгээр тушаал, Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Жижиг, дунд үйлдвэрийн газрын 2025.04.23-ны өдрийн 01/401 албан бичгийн дагуу "Жижиг, дунд үйлдвэрийг дэмжих зээл" төсөл арга хэмжээнд 100.0 сая төгрөгийг зарцуулсан байна.

## **ДҮГНЭЛТ**

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйл, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг хийж байна. Үүнд:

1. Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтыг төлөвлөхдөө төсөвлөлтийн шаардлага хангаагүй төсөл, арга хэмжээг төлөвлөж батлуулсан байна.
2. Худалдан авах ажиллагааг зохион байгуулахад ТХТХ-ийг хэрэгжүүлээгүй байна.
3. Зарим төсөл арга хэмжээг зураг төсвийн дагуу бүрэн хийгээгүй байхад ашиглалтад хүлээн авсан байна.
4. Худалдан авах ажиллагааны шийдвэр, тендерийн үр дүнг цахим системд хугацаанд нь бүрэн мэдээлээгүй байна.

## **ЗӨВЛӨМЖ:**

Аудитын дүн, дүгнэлт нотлох зүйлст үндэслэн дараах зөвлөмжийг өгч байна. Үүнд:

### **I. Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурын дарга /А.Бегарыс/-д:**

1. Аймгийн Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээний төсвийг батлахдаа Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 13.1-д заасныг мөрдөж ажиллах;

### **II. Аймгийн Засаг дарга /Е.Зангар/-д:**

1. Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтад зураг төсөв нь хийгдсэн, төсөвлөлтийн шаардлага хангасан төсөл арга хэмжээг төлөвлөж, батлуулах;
2. Төсөл арга хэмжээний худалдан авах ажиллагаанд Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 13.1-д заасныг мөрдөж ажиллах;
3. Төсөл, арга хэмжээний хэрэгжилтэд тавих хяналт, хариуцлагыг сайжруулах;

### **III. Худалдан авах ажиллагааны газрын дарга /Х.Нурсултан/-д:**

1. Худалдан авах ажиллагааны шийдвэр, тендерийн үр дүнг цахим системд хугацаанд нь мэдээлж ажиллах;

### **IV. Хот байгуулалт, барилга захиалагчийн алба /С.Ержан/-д:**

4. Төсөл, арга хэмжээний гүйцэтгэлд тавих захиалагчийн хяналтыг үр дүнтэй хэрэгжүүлж ажиллах;

Дээрх зөвлөмжүүдийг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг Төрийн аудитын тухай хуулийн 20.5-т заасан хугацаанд буюу аудитын тайланг хүлээн авснаас 30 хоногийн дотор, зөвлөмжийн биелэлтийг 2026 оны 12 дугаар сарын 01-ны өдрийн дотор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх.



БАЯН-ӨЛГИЙ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН  
ДАРГА ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН ТУШААЛ

2026 оны 05 сарын 11 өдөр

Дугаар А/12

Өлгий

Аудитын тайлан баталгаажуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1, 20 дугаар зүйлийн 20.1, 20.4, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/106 дугаар тушаалаар баталсан "Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам"-ын хавсралтын 18 дугаар хэсгийн 18.9, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2025 оны "Эрх шилжүүлэх тухай" А/175 дугаар тушаалын 1 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1."Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын 2025 оны төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн" сэдвээр хийсэн гүйцэтгэлийн аудитын тайланг 1 дүгээр хавсралтаар, аудитаар өгсөн төлбөрийн акт, албан шаардлагыг жагсаалтыг 2 дугаар хавсралтаар баталгаажуулсугай.

2.Аудитын тайланг Нийслэл дэх төрийн аудитын газар болон аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурал, Засаг даргад тус тус хүргүүлсүгэй.

3.Аудитын шийдвэрийн хэрэгжилтэд хяналт тавьж, үр дүнг тооцож ажиллахыг ахлах аудитор (С.Нурлан)-д даалгасугай.

4.Аудитын тайланг баталгаажуулснаас хойш 14 хоногт багтаан аудитын тайлан болон нотлох баримтыг архивын нэгж болгон байгууллагын архивд хүлээлгэж өгөхийг аудитын багт даалгасугай.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН  
АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН  
ГҮЙЦЭТГЭГЧ  Х.ЖЕНИСБЕК



832601000006



**БАЯН-ӨЛГИЙ АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГА**


11 дүгээр баг, Өлгий сум, Баян-Өлгий аймаг, 83129  
Утас: 7042 2483, Факс: (976) 7042 3603,  
Цахим шуудан: info@bo.gov.mn,  
Цахим хуудас: www.bayan-olgi.gov.mn

2026.05.13 № 1/1154  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

**БАЯН-ӨЛГИЙ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАРТ**

“Орон нутгийн төсвийн 2025 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн” сэдэвт аудитын тайлангийн төсөлтэй танилцлаа.

Ямар нэгэн санал байхгүй болно.



ЕЗАНГАР

**8326080625**